



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/433

Арвайхээр

**Орон тоо нэмж батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” 2018 оны А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн нийгмийн ажилтны орон тоог нэгээр нэмэгдүүлж, нийт орон тоог 148-аар, Арвайхээр сумын цэцэрлэг бага сургуулийн цогцолборын цэцэрлэгийн орон тоог 0.5-аар нэмэгдүүлж, нийт орон тоог 16.5-аар тус тус баталсугай.

2. “Орон тоо батлах тухай” Аймгийн Засаг даргын 2019 оны А/46 дугаар захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтын хамт 2019 оны төсвийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагчид үүрэг болгосугай.

3. Батлагдсан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100722